

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

394.	Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1738
395.	Шүүх байгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1744
396.	Төсвийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	1745
397.	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1745
398.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1746
399.	Монгол Улсын 2014 оны төсвийн тухай	1748
400.	Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай	1877
401.	Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай	1880

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

402.	“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 59	1886
403.	Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 60	1886
404.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 61	1887
405.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай	Дугаар 62	1887
406.	Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 63	1891



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн аудитын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг:**

“2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.”

#### **2/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:**

“5.4.Нийцлийн аудит нь аудит хийлгэсэн байгууллага үйл ажиллагаандаа хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актаар тогтоосон шаардлагыг сахин биелүүлж байгаа байдлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гаргана.”

#### **3/6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг:**

“6.2.Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын Ерөнхий аудиторын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо батална.

6.3.Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг үндэслэн төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор шийдвэрлэнэ.”

#### **4/7<sup>1</sup> дүгээр зүйл:**

#### **“7<sup>1</sup> дүгээр зүйл.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага**

7<sup>1</sup>.1.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага нь тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч болон бусад ажилтнаас бүрдэнэ.



7<sup>1</sup>.2.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь төрийн тусгай албан хаагч байна.

7<sup>1</sup>.3.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээчид тавих шаардлага, ажлын байрын тодорхойлолтыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

7<sup>1</sup>.4.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын тэргүүлэх аудитор тухайн аудитын байгууллагын төсвийг захиран зарцуулах ба үйл ажиллагааг нь тогтоосон хугацаанд Үндэсний аудитын газарт хариуцан тайлагнаж, тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд аудитын дүнг танилцуулна.

7<sup>1</sup>.5.Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.”

#### **5/12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэг:**

“12.6.Төрийн аудитын байгууллагын албан тушаалын зэрэг дэвийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно.”

#### **6/15 дугаар зүйлийн 15.1.20 дахь заалт:**

“15.1.20.төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд, түүнчлэн төсвийн хөрөнгөөр болон төсвийн хөрөнгийн оролцоотой хэрэгжих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгуулах хөрөнгө оруулалтын гэрээнд аудит хийж дүгнэлт гаргах;”

**2 дугаар зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 19.4 дэх хэсгийн “Гүйцэтгэлийн” гэсний дараа, 19.1 дэх хэсгийн “гүйцэтгэлийн” гэсний дараа “болон нийцлийн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:**

“5.1.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийнэ. Аудитын арга хэлбэрийг



санхүүгийн удирдлага, шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилттэй уялдуулан байнга боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна.”

**2/6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг:**

“6.1.Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын дээд байгууллага, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэнэ. Төрийн аудитын дээд байгууллага нь Үндэсний аудитын газар, төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага нь аудитын төрөл болон нутаг дэвсгэрийн зарчмаар зохион байгуулагдсан аудитын байгууллага байна.”

**3/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:**

“7.1.Үндэсний аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудитор, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч болон бусад ажилтнаас бүрдэнэ. Монгол Улсын Ерөнхий аудитор, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь төрийн тусгай албан хаагч байна.”

**4/8 дугаар зүйл:**

**“8 дугаар зүйл.Төрийн аудитын байгууллагын төсөв, санхүүжилт**

8.1.Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг хянуулахаар Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд оруулна. Төсвийн байнгын хороогоор хянагдаж зөвшөөрөгдсөн төсвийн төслийг улсын төсөвт нэгтгүүлэхээр төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.

8.2.Төсөв нь төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байх бөгөөд уг төсөвт Үндэсний аудитын газар, төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын үйл ажиллагааны зардлаас гадна лабораторийн шинжилгээ хийлгэх, гэрээт аудитор, мэргэжлийн байгууллага, шинжээч ажиллуулах зардал, ажилтнуудын мэргэшил, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагын хөрөнгө оруулалтад шаардагдах хөрөнгийг тусгана.

8.3.Төрийн аудитын байгууллагын нийт төсвийн төлөвлөлт, зарцуулалтад Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо хяналт тавина.



8.4.Үндэсний аудитын газар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төрийн аудитын байгууллагын жилийн төсвийн хуваарь, аудитын ажлын хэмжээ болон үнэлгээг үндэслэн төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын төсвийн хуваарийг баталж, төлөвлөлт болон зарцуулалтад хяналт тавина.”

**5/12 дугаар зүйлийн 12.3.3-12.3.6 дахь заалт:**

“12.3.3.төрийн аудитын байгууллагын тэргүүлэх аудиторт төрийн аудитын итгэмжит түшээ;

12.3.4.төрийн аудитын байгууллагын аудитын менежерт төрийн аудитын зөвлөх түшээ;

12.3.5.төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээчид төрийн аудитын ахлах түшээ;

12.3.6.төрийн аудитын байгууллагын аудитор, шинжээчид төрийн аудитын түшээ.”

**6/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:**

“13.5.Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхийнхээ зарим хэсгийг тэргүүлэх аудиторт шилжүүлж болох бөгөөд энэ нь түүнийг энэ хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

**7/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:**

“14.1.Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны баталсан зохион байгуулалтын бүтцийн ерөнхий бүдүүвч, орон тооны дээд хязгаарыг үндэслэн төрийн аудитын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах бөгөөд батлагдсан төсөвтөө багтаан төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг томилох, чөлөөлөх эрхтэй.”

**8/15 дугаар зүйлийн 15.1.6, 15.1.7 дахь заалт:**

“15.1.6.гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргын итгэмжилсэн аудитор аудит хийх;

15.1.7.улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийх;”



**9/15 дугаар зүйлийн 15.1.9-15.1.11 дэх заалт:**

“15.1.9.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлт, уг төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан саналын талаарх дүгнэлтийг Улсын Их Хуралд оруулж танилцуулах;

15.1.10.төрийн аудитын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор ажлын зохион байгуулалт, бүтэц, үйл ажиллагааны асуудлаар стандарт, дүрэм, журам, заавар батлах;

15.1.11.өөрийн бүрэн эрхийн асуудлаар төрийн аудитын байгууллагаар сэлгэж аудит хийлгэх;”

**10/15 дугаар зүйлийн 15.2.5 дахь заалт:**

“15.2.5.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх”.

**11/16 дугаар зүйл:**

**“16 дугаар зүйл.Аудитын төлөвлөлт**

16.1.Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулж ажиллана.

16.2.Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа иргэд, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийг сонгож, хүний болон санхүүгийн нөөц, хугацаа, хүрэх үр дүнг тусган Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэр гаргуулна. Энэ шийдвэр нь төлөвлөгөө боловсруулах үндэслэл болно.

16.3.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны шийдвэрээр хийх аудитын тайланг тус Байнгын хороонд заавал танилцуулах бөгөөд уг Байнгын хороо шаардлагатай гэж үзсэн аудитын тайланг хэлэлцэж, зохих шийдвэр гаргана.

16.4.Үндэсний аудитын газар төрийн аудитын байгууллагын аудитын хэтийн болон жилийн төлөвлөгөө боловсруулахдаа дараах зүйлийг харгалзан үзнэ:



16.4.1.дотоод, гадаадын бусад байгууллагын санал;

16.4.2.дотоод хяналтын байгууллагаас хийсэн болон хийхээр төлөвлөсөн аудит;

16.4.3.олон улсын байгууллагаас хийсэн болон хийхээр төлөвлөсөн аудит;

16.4.4.явцын дунд гарч болох гэнэтийн шаардлага.”

**12/18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг:**

“18.5.Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. Ийнхүү гүйцэтгэсэн аудитын тайлангийн чанарыг төрийн аудитын байгууллага баталгаажуулна. Гэрээгээр аудит хийлгэх, аудитын тайланг баталгаажуулах журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.”

**13/28 дугаар зүйл:**

**“28 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

28.1.Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

28.2.Дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ:

28.2.1.аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд;

28.2.2.төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд.”



**4 дүгээр зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчгийн “хэлбэрүүд” гэснийг “төрөл” гэж, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.11 дэх хэсгийн “Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийн” гэснийг “Ерөнхий аудиторын” гэж, 13 дугаар зүйлийн 13.9, 13.12 дахь хэсгийн “Ерөнхий аудитор, Ерөнхий аудиторын орлогчийг” гэснийг “Ерөнхий аудиторыг” гэж, 13.12, 13.13 дахь хэсгийн “тэдгээрийг” гэснийг “түүнийг” гэж, Гуравдугаар бүлгийн гарчиг, 14 дүгээр зүйлийн гарчгийн “боловсон хүчин” гэснийг “хүний нөөц” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “боловсон хүчний” гэснийг “хүний нөөцийн” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.13 дахь заалтын “шийтгэл ногдуулах” гэснийг “хариуцлага тооцуулах” гэж, мөн зүйлийн 15.2 дахь хэсгийн “Аймаг, нийслэлийн аудитын газар” гэснийг “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага” гэж, 15.3 дахь хэсгийн “Төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас” гэснийг “Төрийн аудитын байгууллагаас” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.20 дахь заалтын дугаарыг “15.1.21” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.8, 13.10, 13.13 дахь хэсгийн “, Ерөнхий аудиторын орлогч” гэснийг, 18 дугаар зүйлийн гарчгийн “, түүний тайлан” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалтын “аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 9, 10 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1.6, 12.3.2 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн Нэг дэх хэсгийн 1 дэх заалт, Хоёр дахь хэсгийн 1 дэх заалтын “Баянзүрх дүүрэг” гэснийг “Улаанбаатар хот /зүүн бүс/” гэж, мөн зүйлийн Нэг дэх





хэсгийн 2 дахь заалт, Хоёр дахь хэсгийн 2 дахь заалтын “Сонгинохайрхан дүүрэг” гэснийг “Улаанбаатар хот /баруун бүс/” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.2 дахь заалт, 43.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### **ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.2.Боловсролын тухай хуулийн 28.1.8-д заасны дагуу аттестатчилагдсан, сүүлийн жилийн төгсөгчдийн тодорхой хувь нь мэргэжлээрээ ажлын байраар хангагдсан дээд боловсролын сургалтын



байгууллагад, энэ хуулийн 7.1.1-д заасан шаардлагыг ханган өдрийн ангид суралцаж байгаа суралцагчдын сурлагын амжилтыг нь харгалзан суралцах хугацаанд нь 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн 10 сарын турш, сар бүр үндэсний тэтгэлгийг олгоно. Үндэсний тэтгэлгийг олгох сургалтын байгууллага болон суралцагчид тавигдах шаардлага, хичээлийн нэг жил, сард олгох хэмжээ, хугацааг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар тогтооно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2014 ОНЫ  
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2015-2016 ОНЫ  
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“1 дүгээр зүйл.**Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2014 он	2015 он	2016 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	14.8	16.0	14.8
2	Хэрэглээний үнийн индексийн дундаж түвшин	8.0	7.0	6.0



3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,883.9	8,210.6	9,456.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.6	33.5	32.3
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,293.9	8,696.8	10,041.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.6	35.5	34.3
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /хувь/	10.0	19.2	15.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.2	5.7	4.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-410.0	-486.2	-584.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,006.2	2,809.8	3,246.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	9.8	11.5	11.1
8	Улсын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	8,201.2	9,797.9	11,444.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	40.0	40.0	39.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	266.8	318.9	350.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.3	1.3	1.2

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлого, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль<sup>2</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл.Монгол Улсын төсөвт 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

<sup>1</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн



Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b>	<b>20.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	20.0
2	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>10.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	10.0
3	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>	<b>800.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	800.0
4	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b>	<b>65.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	65.0
5	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>	<b>4.1</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	4.1
6	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b>	<b>14.4</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	14.4
7	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>8,083.8</b>
	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	3,927.0
	Цөмийн энергийн газар	2,545.6
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,611.2
8	<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>15,388.8</b>
	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	1,154.0
	Оюуны өмчийн газар	600.0
	Стандартчилал, хэмжил зүйн газар	1,683.3
	Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар	1,212.1
	Хилийн мэргэжлийн хяналтын алба	479.1
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	5,010.3
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,250.0	
9	<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>2,347.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,347.0
10	<b>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд</b>	<b>226.1</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	226.1
11	<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>15,720.6</b>
	Дипломат төлөөлөгчийн газрууд	10,519.1
	Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар улсын төсөвт үйлдвэрийн газар	4,221.5
12	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	980.0
	<b>Сангийн сайд</b>	<b>4,096,841.5</b>
	Татварын ерөнхий газар	2,078,909.4
	үүнээс: Төсвийн тогтворжуулалтын сан	29,799.6
	Гаалийн ерөнхий газар	1,919,915.7
	Сангийн яам	28,595.6
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	65,739.1	
Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	3,681.7	



13	<b>Хууль зүйн сайд</b>	<b>49,402.9</b>
	Улсын бүртгэлийн ерөнхий газар	12,908.1
	Замын цагдаагийн газар	1,875.0
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	22,177.1
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	841.5
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	11,601.1
14	<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>4,200.0</b>
	Барилга, хот байгуулалтын яам	1,200.0
	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	2,550.0
	Зураг төсөл, эрдэм шинжилгээний институт	450.0
15	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>22,230.0</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	4,822.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	17,408.0
16	<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	<b>1,729.5</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,729.5
17	<b>Зам тээврийн сайд</b>	<b>73,893.5</b>
	Иргэний нисэхийн ерөнхий газар	67,919.0
	“Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компани	802.9
	Зам тээврийн яам	1,584.4
	Авто замын хяналт, эрдэм шинжилгээ, судалгааны төв улсын төсөвт үйлдвэрийн газар	2,350.0
	Монгол Улсын далайн захиргаа	274.4
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	962.8
18	<b>Соёл, спорт, аялал жуулчлалын сайд</b>	<b>1,472.7</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	1,472.7
19	<b>Уул уурхайн сайд</b>	<b>250,085.5</b>
	Ашигт малтмалын газар	28,912.2
	Газрын тосны газар	221,168.1
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5.2
20	<b>Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд</b>	<b>64,709.4</b>
	Төрийн өмчийн хороо	34,723.4
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	24,000.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	5,986.0
21	<b>Хөдөлмөрийн сайд</b>	<b>151,328.0</b>
	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт	50,000.0
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	101,328.0
22	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>3,225.2</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	576.8
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	2,648.3



23	<b>Эдийн засгийн хөгжлийн сайд</b>	<b>45.0</b>
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	45.0
24	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>136,660.2</b>
	Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого	123,395.3
	Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого	13,264.9

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын төсөвт 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 4,676,370.5 сая төгрөгөөр баталсугай.

**5 дугаар зүйл.** Монгол Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарт доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b>	<b>9,651.8</b>
	Урсгал зардал	9,611.8
	Хөрөнгийн зардал	40.0
2	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b>	<b>26,133.5</b>
	Урсгал зардал	23,393.5
	Хөрөнгийн зардал	2,740.0
3	<b>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга</b>	<b>794.5</b>
	Урсгал зардал	794.5
4	<b>Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч</b>	<b>4,365.1</b>
	Урсгал зардал	4,365.1
5	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b>	<b>59,635.6</b>
	Урсгал зардал	59,635.6
6	<b>Хүний эрхийн үндэсний комиссын дарга</b>	<b>990.0</b>
	Урсгал зардал	885.0
	Хөрөнгийн зардал	105.0
7	<b>Улсын ерөнхий прокурор</b>	<b>19,932.2</b>
	Урсгал зардал	18,282.2
	Хөрөнгийн зардал	1,650.0
8	<b>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга</b>	<b>1,713.9</b>
	Урсгал зардал	1,713.9



9	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>	<b>8,875.8</b>
	Урсгал зардал	7,813.6
	Хөрөнгийн зардал	1,062.2
10	<b>Авлигатай тэмцэх газрын дарга</b>	<b>14,819.5</b>
	Урсгал зардал	11,287.7
	Хөрөнгийн зардал	3,531.8
11	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>	<b>2,818.0</b>
	Урсгал зардал	2,818.0
12	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b>	<b>783.7</b>
	Урсгал зардал	783.7
13	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b>	<b>9,643.7</b>
	Урсгал зардал	9,165.3
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	478.4
14	<b>Сонгуулийн ерөнхий хорооны дарга</b>	<b>911.7</b>
	Урсгал зардал	881.7
	Хөрөнгийн зардал	30.0
15	<b>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга</b>	<b>927.3</b>
	Урсгал зардал	927.3
16	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>107,422.7</b>
	Урсгал зардал	68,283.0
	Хөрөнгийн зардал	39,139.7
17	<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>121,945.0</b>
	Урсгал зардал	85,968.8
	Хөрөнгийн зардал	35,976.2
18	<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>21,037.2</b>
	Урсгал зардал	16,454.5
	Хөрөнгийн зардал	4,582.7
19	<b>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд</b>	<b>74,939.7</b>
	Урсгал зардал	62,591.0
	Хөрөнгийн зардал	12,348.7
20	<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>52,518.1</b>
	Урсгал зардал	44,108.1
	Хөрөнгийн зардал	8,410.0





21	<b>Сангийн сайд</b>	<b>1,963,454.9</b>
	Урсгал зардал	981,375.1
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	34,734.7
	Хөрөнгийн зардал	146,224.8
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	28,526.6
	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт	544,839.8
	Засгийн газрын гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт	128,962.4
	Засгийн газрын дотоод зээлийн үндсэн төлбөрт	98,791.5
22	<b>Хууль зүйн сайд</b>	<b>372,298.1</b>
	Урсгал зардал	357,170.8
	Хөрөнгийн зардал	15,127.3
23	<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>208,079.8</b>
	Урсгал зардал	13,578.4
	Үүнээс: Газрын харилцаа, кадастрын тусгай зориулалтын шилжүүлэг	6,994.7
	Хөрөнгийн зардал	162,978.0
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	31,523.4
24	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>189,828.8</b>
	Урсгал зардал	161,298.4
	Хөрөнгийн зардал	28,530.4
25	<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	<b>1,096,472.0</b>
	Урсгал зардал	944,229.2
	Үүнээс: Сургуулийн өмнөх боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	214,183.4
	Ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлэг	502,164.8
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	12,137.2
	Хөрөнгийн зардал	126,469.9
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	13,635.7
26	<b>Зам, тээврийн сайд</b>	<b>295,343.3</b>
	Урсгал зардал	14,613.9
	Хөрөнгийн зардал	112,109.6
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	168,619.7
27	<b>Соёл, спорт, аялал жуулчлалын сайд</b>	<b>146,939.0</b>
	Урсгал зардал	82,312.6
	Үүнээс: Соёлын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	38,599.0



	Нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	145.4
	Соёл, нийтийн биеийн тамирын тусгай зориулалтын шилжүүлэг	9,265.7
	Хөрөнгийн зардал	64,626.4
28	<b>Уул, уурхайн сайд</b>	<b>24,993.1</b>
	Урсгал зардал	10,973.1
	Хөрөнгийн зардал	14,020.0
29	<b>Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд</b>	<b>189,500.4</b>
	Урсгал зардал	127,173.3
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	1,500.0
	Хөрөнгийн зардал	57,217.5
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	3,609.6
30	<b>Хөдөлмөрийн сайд</b>	<b>237,999.1</b>
	Урсгал зардал	178,892.4
	Дотоод эх үүсвэрээс олгох зээл	28,000.0
	Хөрөнгийн зардал	31,106.7
31	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>443,569.6</b>
	Урсгал зардал	414,605.2
	Үүнээс: Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	6,226.3
	Хөрөнгийн зардал	28,964.4
32	<b>Эдийн засгийн хөгжлийн сайд</b>	<b>57,793.3</b>
	Урсгал зардал	8,836.0
	Хөрөнгийн зардал	48,957.3
33	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>566,163.9</b>
	Урсгал зардал	447,626.2
	Үүнээс: Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг	91,853.1
	Хөрөнгийн зардал	93,515.2
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	25,022.5
34	<b>Эрчим хүчний сайд</b>	<b>202,011.8</b>
	Урсгал зардал	36,028.5
	Хөрөнгийн зардал	147,428.3
	Гадаад төслийн зээлээс санхүүжих зардал	18,555.1

**6 дугаар зүйл.** Монгол Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн/ хэмжээг 5,594,785.9 сая төгрөгөөр баталсугай.



**7 дугаар зүйл.**Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2014 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээг 1,143,275.5 сая төгрөгөөр баталсугай.

**8 дугаар зүйл.**Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2014 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээг 29,799.6 сая төгрөгөөр баталсугай.

**9 дүгээр зүйл.**Монгол Улсын 2014 оны төсвийн жилд төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг доор дурдсанаар баталсугай:

9.1.Шинээр гаргах болон дахин санхүүжүүлэх Засгийн газрын он дамжих үнэт цаас 1,400,000.0 сая төгрөг;

9.2.Засгийн газрын шинээр авах гадаад төслийн зээл 289,971.1 сая төгрөг.

**10 дугаар зүйл.**Монгол Улсын 2014 оны төсвийн жилд Засгийн газрын гаргах баталгааны дээд хязгаарыг 2,500,000.0 сая төгрөгөөр тогтоосугай.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ,  
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ  
ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГААС  
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН  
ШИЛЖҮҮЛЭГ**

**11 дүгээр зүйл.**Монгол Улсын 2014 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	12,666.0
2	Баян-Өлгий	11,535.3
3	Баянхонгор	12,263.7
4	Булган	2,254.7
5	Говь-Алтай	9,420.9
6	Дорнод	5,952.5



7	Дундговь	8,288.5
8	Завхан	11,072.4
9	Өвөрхангай	13,749.9
10	Сүхбаатар	8,491.0
11	Сэлэнгэ	4,230.3
12	Төв	10,248.8
13	Увс	10,595.9
14	Ховд	9,434.6
15	Хөвсгөл	18,957.5
16	Хэнтий	9,675.0
17	Говьсүмбэр	333.5
<b>Нийт дүн</b>		<b>159,170.7</b>

**12 дугаар зүйл.**2014 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Өмнөговь	26,582.8
2	Улаанбаатар	44,044.2
3	Орхон	711.6
<b>Нийт дүн</b>		<b>71,338.5</b>

**13 дугаар зүйл.**2014 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	11,877.6
2	Баян-Өлгий	10,328.8
3	Баянхонгор	13,744.2
4	Булган	9,945.3
5	Говь-Алтай	13,324.1
6	Дорноговь	10,909.0
7	Дорнод	12,016.3



8	Дундговь	10,711.5
9	Завхан	11,116.7
10	Өвөрхангай	13,144.4
11	Өмнөговь	13,112.9
12	Сүхбаатар	11,291.6
13	Сэлэнгэ	9,852.4
14	Төв	10,307.5
15	Увс	10,878.3
16	Ховд	11,815.3
17	Хөвсгөл	12,840.6
18	Хэнтий	11,239.1
19	Дархан-Уул	9,149.6
20	Улаанбаатар	48,760.3
21	Орхон	10,124.4
22	Говьсүмбэр	7,911.2
<b>Нийт дүн</b>		<b>284,400.8</b>

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

**14 дүгээр зүйл.** “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2014 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

**15 дугаар зүйл.** “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

**16 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Монгол Улсын 2014 оны төсвийн тухай  
хуулийн 1 дүгээр хавсралт

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2014 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ  
ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН  
ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2014 оны зорилтот түвшин
1	<p><b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА</b></p> <p><b>1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа</b></p> <p>1.1.1 Эрх зүй, аюулгүй байдал, төр болон улс төрийн салбарт тулгамдаж байгаа шинэтгэлийн бодлогыг үргэлжлүүлэх</p> <p>1.1.2 Иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах эрхийг хангасан байгальд ээлтэй, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх</p> <p>1.1.3 Монгол Улсын аюулгүй, тусгаар, бие даасан байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, санал санаачлагыг дэмжих</p> <p><b>1.2 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагаа</b></p> <p>1.2.1 Нийслэлийн агаарын бохирдлыг 2011 онтой харьцуулахад бууруулах хувь</p> <p><b>1.3 Төрийн нийтлэг судалгаа, шинжилгээ</b></p> <p>1.3.1 Монгол Улсын хөгжлийн нөөц боломж, хувилбаруудын судалгаа</p> <p>1.3.2 Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд урт, дунд хугацаанд чухал нөлөөтэй гол асуудлуудын судалгаа</p>	<p>төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх</p> <p>төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх</p> <p>тухай бүрт дэмжиж ажиллах</p> <p>45.0</p> <p>төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх</p> <p>төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх</p>
2	<p><b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b></p> <p><b>2.1 Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих</b></p> <p>2.1.1 Улсын Их Хурлын чуулганы хуралдаан</p>	<p>хуульд заасан хугацаанд хуралдсан байх</p>



	<p>2.1.2 Чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлыг хэлэлцүүлэх хувь 85</p> <p>2.1.3 Чуулганаар хэлэлцсэн асуудлыг шийдвэрлэх хувь 100</p> <p>2.1.4 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан мэдээллийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх тоо 4-өөс доошгүй удаа</p> <p>2.1.5 Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг байгууллагын тайланг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх байгууллага тус бүрт 1-ээс доошгүй удаа</p> <p><b>2.2 Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх</b></p> <p>2.2.1 Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах хуульд заасны дагуу хангагдсан байх</p>	
<b>3</b>	<p><b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА</b></p> <p><b>3.1 Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, Монгол Улсын Үндсэн хуулийг чандлан сахиулах</b></p> <p>3.1.1 Өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлтийн барагдуулалт /хувиар/ 85.0</p> <p>3.1.2 Бага суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт /хувиар/ 85.0</p> <p>3.1.3 Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн дунд, их суудлын хуралдаанаар шийдвэрлэсэн өргөдлийн барагдуулалт /хувиар/ 85.0</p>	
<b>4</b>	<p><b>УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ</b></p> <p><b>4.1 Хяналтын шатны шүүн таслах ажлыг эрхлэх, шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах</b></p> <p>4.1.1 Хяналтын шатны журмаар хуулийн хугацаанд шийдвэрлэх хэргийн хувь 79.1</p>	



	4.1.2	Ирсэн өргөдөл, гомдол, хэргийг хууль тогтоомжид заасан хугацаанд хянан шийдвэрлэх /хувиар/	82.0
<b>5</b>	<b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>		
	<b>5.1</b>	<b>Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах</b>	
	5.1.1	Хуулийн хугацаанд шийдвэрлэх хэргийн хувь	93.0
<b>6</b>	<b>ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА</b>		
	<b>6.1</b>	<b>Хүний эрхийн хамгаалалт</b>	
	6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл	1
	6.1.2	Хүний эрх, эрх чөлөөний талаар хийсэн хяналт шалгалт, судалгааны тоо /шалгалт, судалгаа, шинжилгээний тоо/	15/8/25
	6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх өргөдөл, гомдол шийдвэрлэх	650
	6.1.4	Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх асуудлаар шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах асуудлаар зөвлөмж хүргүүлэх	5~25
	6.1.5	Хүний эрхийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа	50 удаагийн 250 цаг, 3000 оролцогчтой
	6.1.6	Хүний эрхийн асуудлаар олон нийтэд зориулсан ном товхимол, эвхмэл хуудас, зурагт хуудас зэргийг гаргах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сурталчилгааны үйл ажиллагаа	15 төрөл 20000 ширхэг, 53 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 400 удаа
<b>7</b>	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>		
	<b>7.1</b>	<b>Прокурорын хяналт</b>	
	7.1.1	Хэрэг бүртгэлийн ажиллагаанд тавих хяналт /хувиар/	100
	7.1.2	Ялтны хувийн хэрэгт хийх шалгалтын тоо	760





	7.1.3	Хорих анги, цагдан хорих байрны үйл ажиллагаатай биечлэн танилцах /тоогоор/	5950
8	<b>ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА</b>		
	<b>8.1 Бодлогын зөвлөгөө</b>		
	8.1.1	Бодлогын зөвлөмжийн тоо	80
	<b>8.2 Судалгаа шинжилгээ</b>		
	8.2.1	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо	90
9	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</b>		
	<b>9.1 Төрийн аудитын удирдлага, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит</b>		
	9.1.1	Санхүүгийн аудит хийх байгууллагын тоо /мянгаар/	4.3
	9.1.2	Гүйцэтгэлийн аудит хийх байгууллагын тоо	14
	9.1.3	Нэвтрүүлэх стандартын тоо	2171
10	<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА</b>		
	<b>10.1 Авлигатай тэмцэх үйл ажиллагаа</b>		
	10.1.1	Хөрөнгө орлогын мэдүүлэгт нарийвчилсан судалгаа хийх хувь	20.0
	10.1.2	Эрх бүхий албан тушаалтанд зориулсан сургалтын тоо	1400
	10.1.3	Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны тоо	30
	10.1.4	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тухай сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	50.0
	10.1.5	Шударга байдлын түвшин тогтоох үнэлгээ хийх тоо	1
	10.1.6	Авлигын индексийг тодорхойлох судалгааны тоо	1
10.1.7	Байгууллага, иргэдийн гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	95	



11	<p><b>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА</b></p> <p><b>11.1 Санхүүгийн салбарын зохицуулалт</b> 11.1.1 Олгох зөвшөөрлийн тоо</p> <p><b>11.2 Санхүүгийн хяналт шалгалт</b> 11.2.1 Хяналт шалгалтын тоо</p>	<p>3362</p> <p>445</p>
12	<p><b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b></p> <p><b>12.1 Төрийн захиргаа, төрийн албаны удирдлага, бодлого</b></p> <p>12.1.1 Салбар зөвлөл тус бүрийг мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний бодлого, хүний нөөцийн хөгжлийн бодлого, стандартын удирдлагаар хангах</p> <p>12.1.2 Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход авах мэргэшлийн шалгалт зохион байгуулах</p> <p>12.1.3 Зорилтот бүлгүүдэд чиглэсэн зайны болон захиалгат сургалтыг зохион байгуулах</p>	<p>3-аас доошгүй удаа</p> <p>50 удаа</p> <p>30 удаа</p>
13	<p><b>ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА</b></p> <p><b>13.1 Албан ёсны статистикийг хөгжүүлэх</b></p> <p>13.1.1 Албан ёсоор гаргах статистикийн мэдээ тайлангийн нэр төрөл</p> <p>13.1.2 Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тоо /мянгаар/</p> <p>13.1.3 Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт</p> <p>13.1.4 Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилж эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо</p> <p><b>13.2 Улсын хэмжээний тооллого</b></p> <p>13.2.1 Статистикийн тухай хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний тооллогын тоо</p> <p><b>13.3 Улсын хэмжээний судалгаа</b></p> <p>13.3.1 Статистикийн тухай хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний статистик судалгааны тоо</p>	<p>290</p> <p>112.1</p> <p>45</p> <p>20</p> <p>1</p> <p>4</p>



14	<b>СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА</b>		
	<b>14.1 Сонгуулийн ерөнхий удирдлага</b>		
	14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам, заавар, маягтыг боловсруулах	журам, заавар 10, маягт 7
	<b>14.2 Сонгууль зохион байгуулах</b>		
	14.2.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	2
	14.2.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /хувиар/	2.0
	14.2.4	Тойрог болон нутаг дэвсгэрийн хорооны үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	10
14.3	<b>Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглах, хэрэглэх ажлыг зохион байгуулах</b>		
	14.3.1	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагааг хангах засвар үйлчилгээ үзүүлэх тоо	5000
	14.3.2	Программ хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх
15	<b>ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА</b>		
	<b>15.1 Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах</b>		
	15.1.1	Улс төрийн хэлмэгдэгчийн дурсгал “Цагаан ном”-ын цуврал боть	1
	<b>15.2 Улс төрийн талаар хилс хэрэгт хэлмэгдэгчийн нөхөн олговор, хөнгөлөлт</b>		
	15.2.1	Орон сууцны дэмжлэг авах иргэний тоо	10
15.3	<b>Хэлмэгдэгчийн талаар хийх судалгаа, шинжилгээ</b>		
	15.3.1	Зохион байгуулах эрдэм шинжилгээний бага хурлын тоо	2
16	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД</b>		
	<b>16.1 Хүйсийн тэгш байдлыг хангах</b>		
	16.1.1	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	20.0
	16.1.2	Улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	15.0



	16.1.3	Төрийн захиргааны удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	15.0
	16.1.4	Төрийн тусгай албан тушаалд /зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад/ эмэгтэйчүүдийн эзлэх хувь	40.0
	16.1.5	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	40.0
	16.1.6	Үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувь	40.0
	<b>16.2</b>	<b>Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтцийг сайжруулах</b>	
	16.2.1	Их багтаамжийн IP/MPLS, DWDM системд суурилсан өндөр хурдны мэдээллийн сүлжээний тоног төхөөрөмж нийлүүлэх цэгийн тоо	1 төв зангилаа цэг
	16.2.2	Газар хөдлөлтийн гамшгийг урьдчилан анхааруулах систем суурилуулалтын хувь	100%
	16.2.3	Шинээр байгуулах сувагчлалын урт /км/	25
	16.2.4	Иргэдийн өргөдөл, гомдлын мэдээллийн ухаалаг тайлангийн систем төрийн үйлчилгээний цахим машин суурилуулах цэгийн тоо	59
	16.2.5	Үүрэн холбооны үйлчилгээнд шинээр хамруулах багийн тоо	60
	16.2.6	Мэдээлэл шифрлэж дамжуулах төрийн байгууллагын тоо	45
	16.2.7	Төрийн үйлчилгээний цахим нэг цонхны мэдээллийн систем суурилуулах хувь	50
	16.2.8	Төрийн мэдээллийн санд мэдээллээ төвлөрүүлэн, шилжүүлэх байгууллагын тоо	15
	16.2.9	Шинээр үүрэн холбооны үйлчилгээг хүргэх багийн тоо	10



<b>16.3</b>	<b>Төрийн тусгай хамгаалалт</b>	
16.3.1	Хамгаалуулагчийн санал, хүсэлтийг барагдуулах /хувь/	100.0
16.3.2	Хамгаалуулагчийн аюулгүй байдал хангагдсан байх	бүрэн хангагдсан байх
16.3.3	Үйлчлүүлэгчийн санал, хүсэлтийг барагдуулах /хувь/	100.0
16.3.4	Үйлчилгээний стандарт, зочид буудлын стандартыг хангах	MNS 4588:2008, MNS 4946:2005 стандартуудыг хангасан байх
<b>16.4</b>	<b>Олборлолт, уул, уурхайн ил тод байдал</b>	
16.4.1	Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын нэгдсэн тайлан гаргасан байх /тайланд хамрагдах аж ахуйн нэгжийн тоо/	250
<b>16.5</b>	<b>Цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого</b>	
16.5.1	Цөмийн болон цацрагийн хяналт шалгалт зохион байгуулах	340
16.5.2	Цацрагийн хэмжилт, шинжилгээ явуулах	1800
16.5.3	Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх тоо	155
16.5.4	Үндэсний стандарт, дүрэм, журам, заавар шинэчлэн боловсруулах	14
<b>16.6</b>	<b>Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа</b>	
16.6.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /ширхэгээр/	237000
16.6.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /ширхэгээр/	266400
16.6.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх /хувиар/	3
16.6.4	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувиар/	5



<b>XXV.3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>56003,4</b>	<b>29309,8</b>
	Шилжих			44345,1	18151,5
XXV.3.1	Клиникийн II нэгдсэн эмнэлэг /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	3000,0	1500,0
XXV.3.2	П.С.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг / Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2014	5500,0	2500,0
XXV.3.3	Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	8000,0	3000,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXV.3.4	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн шим тэжээл, хор судлал, биотехнологийн үндэсний үйлдвэрлэл/Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	2000,0	1000,0
XXV.3.5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	7702,9	1851,5
XXV.3.6	Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн тохижилт, тоног төхөөрөмж	2013	2014	4000,0	1500,0
XXV.3.7	Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж	2013	2014	2000,0	1000,0
XXV.3.8	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин	2013	2014	2000,0	800,0
XXV.3.9	Зүрх судасны тусламж үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж	2013	2014	2842,2	1200,0
XXV.3.10	Гемодиализын тусламж үйлчилгээг клиникийн зарим эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд шинээр байгуулах	2013	2014	1500,0	800,0
XXV.3.11	Ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ, үйлчилгээний тусламж үйлчилгээг сайжруулах	2013	2014	3500,0	1500,0
XXV.3.12	Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2013	2014	2300,0	1500,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
	Шинэ			11658,3	11158,3
XXV.3.13	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1000,0	1000,0
XXV.3.14	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохиргооны төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	500,0	500,0
XXV.3.15	Удамзүйн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1300,0	1300,0
XXV.3.16	Оношлогооны төвийн тоног төхөөрөмж /Аймгуудад/	2014	2014	3214,3	3214,3
XXV.3.17	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмж /Дорнод, Хэрлэн сум/	2014	2014	360,0	360,0
XXV.3.18	Аймгуудын Эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар /Дархан-Уул, сумдууд; Сэлэнгэ, Баянгол сум/	2014	2015	1000,0	500,0
XXV.3.19	Дүүргийн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	2300,0	2300,0
XXV.3.20	Амаржих газруудад эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмж /Аймаг/	2014	2014	1200,0	1200,0
XXV.3.21	Үргүйдлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эвсэл үр шилжүүлэн суулгах лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	420,0	420,0
XXV.3.22	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ	2014	2014	364,0	364,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			678522,0	147428,3
XXVI.1	I.Хөрөнгө оруулалт			677962,0	147168,3
	Цахилгаан дамжуулах шугам, дэд станц			298633,4	70763,6
	Шилжих			202974,3	32086,4
XXVI.1.1	Дундговь аймгийн Мандалговь-Өмнөговь аймгийн Тавантолгой-Оюутолгойн 2 хэлхээтэй 220 кВ-ын 429 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Өмнөговь/	2010	2014	160000,0	15000,0
XXVI.1.2	Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгож нэмэгдүүлэх /Орхон/	2012	2014	6923,9	2443,9
XXVI.1.3	Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Улаанбаатар/	2013	2014	8100,0	4100,0
XXVI.1.4	Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2013	2014	6880,0	3000,0
XXVI.1.5	Сумын 15 кВ-ын 61 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Баянхонгор, Шинэжинст, Баянцагаан сум/	2013	2014	1800,0	1000,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.6	Хархорин, Мөрөн дэд станцад тус бүр 2 ком 6, 10 кВ-ын удирдлагатай реактор, Сайншанд дэд станцад 2 ком 35 кВ-ын синхрон компенсатор суурилуулах /Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь/	2013	2014	720,0	720,0
XXVI.1.7	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Ховд, Жаргалант сум/	2013	2014	1750,0	1750,0
XXVI.1.8	35/10 кВ-ын Баянзүрх дэд станцын хүчин чадлыг 2х10 МВА болгож нэмэгдүүлэх /Улаанбаатар/	2012	2014	1699,2	252,1
XXVI.1.9	Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/	2013	2014	1598,3	798,3
XXVI.1.10	Баруунтуруун сумын Хар-цагаан усны үтрэм, Булганхангай багийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Увс/	2012	2014	1047,1	9,8
XXVI.1.11	Өндөр-Улаан сумын Хануй багийн 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Архангай/	2012	2014	596,6	91,0
XXVI.1.12	Дархан хотын 110/6 кВ-ын Давхар дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/	2012	2014	2381,1	102,2
XXVI.1.13	Тамсаг-Халх голын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2014	2015	4450,0	2658,5



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.14	Чойбалсан 110/35/6 кВ-ын дэд станцыг 16 МВАх2 трансформатораар өргөтгөх /Дорнод/	2011	2014	1929,9	96,5
XXVI.1.15	Оюутолгой-Баян-Овоо сум, Тавантолгой-Манлай сумын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Өмнөговь/	2011	2014	2759,8	28,1
XXVI.1.16	Бат-Өлзий сумын төвөөс Орхоны хүрхрээгээр дайрч Улаан амны баг хүртэлх 10 кВ-ын 30 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Өвөрхангай/	2012	2014	338,4	36,0
	Шинэ			95659,1	38677,2
XXVI.1.17	Умард дэд станцаас кабель шугам татаж 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2015	2523,1	1000,0
XXVI.1.18	1 дүгээр хорооллын ХТП5-ын дэргэд 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих /Улаанбаатар/	2014	2015	1015,5	515,5
XXVI.1.19	Амгалан дэд станцаас кабель шугам татаж ХТП208-ын дэргэд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2015	1000,6	500,0
XXVI.1.20	35/6 кВ-ын Баянхошуу 2х10 МВА чадалтай шинэ дэд станц барьж, 35 кВ-ын 7.2 км 2 хэлхээ ЦДАШ татах /Улаанбаатар/	2014	2015	2021,1	800,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.21	35/10 кВ-ын Дашчойнхор 2х6.3 МВА чадалтай шинэ дэд станц барих /Улаанбаатар/	2014	2015	1897,0	897,0
XXVI.1.22	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /Улаанбаатар/	2014	2015	9000,0	2500,0
XXVI.1.23	Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/	2014	2015	6000,0	2250,9
XXVI.1.24	Үйлдвэрийн районы 35 кВ-ын 35/6 кВ-ын 2х6300 кВА дэд станц, 35кВ-ын хуурай салгуурын пунктын өргөтгөл /Дархан-Уул/	2014	2015	4097,2	2000,0
XXVI.1.25	Хөтөл хорооны 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Дархан-Уул, Дархан сум, Хөтөл хороо/	2014	2015	1822,4	822,4
XXVI.1.26	Байдлаг дэд станцыг 35/10кВ-ын дэд станц болгон өргөтгөх, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах / Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2015	1499,7	799,7
XXVI.1.27	Хаалттай хуваарилах байгууламж 7-гийн өргөтгөл /Улаанбаатар/	2014	2015	1800,0	900,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.28	Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 7,6 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2015	9000,0	4500,0
XXVI.1.29	Завхан сумаас Хэцүү хад хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, 15/0,4 кВ-ын дэд станц /Увс, Завхан сум/	2014	2014	847,0	847,0
XXVI.1.30	Айраг-Даланжаргалан 35 кВ-ын 25.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь/	2014	2015	1290,0	690,0
XXVI.1.31	Баруун-Урт-Талбулагийн 10 кВ-ын 34.9 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Сүхбаатар/	2014	2014	477,7	477,7
XXVI.1.32	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2015	3940,0	1817,0
XXVI.1.33	Баруун-Урт-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 110/35/6 кВ-ын дэд станц / Сүхбаатар/	2014	2015	8900,0	3000,0
XXVI.1.34	Багуудын цахилгаан хангамжийг сайжруулах /Дорнод, Хэрлэн сум, 1,8 дугаар баг/	2014	2014	700,0	700,0





Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.35	“Булган хангай” хорооллыг дулаан, цахилгаан эрчим хүчээр хангах /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2014	1800,0	1800,0
XXVI.1.36	Цахилгаан дамжуулах агаарын шугам /Увс, Цагаанхайрхан сум, Хунт, Хулж баг/	2014	2014	360,0	360,0
XXVI.1.37	35 кВ-ын 25 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Баян-Өлгий, Сарсай, Улаанхус сум/	2014	2015	2000,0	1000,0
XXVI.1.38	10/0.4 кВ-ын 24.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь, Эрдэнэ сум, “Бүрдэнэбулаг” бөөрний сувилал/	2014	2015	1000,0	500,0
XXVI.1.39	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0,4 кВ-ын 2х630 кВа ХТП-15 ком, 6 кВ-ын 34,9 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	2014	2016	10217,2	3500,0
XXVI.1.40	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0,4 кВ-ын 2х630 кВа ХТП-8 ком, 6 кВ-ын 10,5 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 2, 3 дугаар хороолол/	2014	2016	5450,6	1500,0
XXVI.1.41	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт	2014	2016	17000,0	5000,0
XXVI.1.42	<b>Дулааны цахилгаан станц, дулааны шугам</b>			<b>363913,6</b>	<b>73395,7</b>
	Шилжих			95968,5	34175,7



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.43	Дулааны сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум, Төв зах, Гурван Эрдэнэ сургууль, Зүүн талын шинэ хороолол/	2012	2014	5000,0	3500,0
XXVI.1.44	Дулааны станц, шугам сүлжээ /Ховд, Жаргалант сум/	2011	2014	16000,0	9602,0
XXVI.1.45	Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2014	2981,0	1481,0
XXVI.1.46	Дулааны цахилгаан станц 2-ын цахилгаан тоноглолын шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	2194,5	1194,5
XXVI.1.47	Дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх /Сэлэнгэ, Сүхбаатар/	2013	2014	1492,6	742,6
XXVI.1.48	Шинээр баригдах орон сууцны 11, 12, 13 дугаар хороолол руу дулааны шугам шинээр тавих, хуучин шугамыг өргөтгөх /Дархан-Уул, Дархан сум/	2013	2014	1711,4	811,4
XXVI.1.49	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2013	2014	3538,3	1138,3
XXVI.1.50	6д магистралийн Тк-639-өөс Тк-643 хүртэлх 1223 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	2548,5	1298,5
XXVI.1.51	2 г, д магистралийн Тк-226-аас Тк-234 хүртэлх 1400 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	1531,5	531,5



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.52	Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2014	15931,3	11931,3
XXVI.1.53	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2010	2014	13000,0	7,8
XXVI.1.54	Дулааны станц барих /Хөвсгөл/	2010	2014	7966,3	583,6
XXVI.1.55	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Хөвсгөл/	2010	2014	5956,3	271,6
XXVI.1.56	Дулааны станц барих /Увс, Улаангом сум/	2011	2014	7435,0	962,7
XXVI.1.57	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Увс/	2011	2014	4919,2	9,7
XXVI.1.58	ДЦС-2-оос Тк-844 хүртэлх Ш350 мм, Ш400 мм голчтой 2130 хос м шугамыг Ш700 мм, Ш600 мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх /Улаанбаатар/	2011	2014	1835,8	32,8
XXVI.1.59	Дулааны ЗД магистрал шугамын шинэчлэл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2014	1438,0	34,2
XXVI.1.60	Дулааны станц, дулааны шугам сүлжээний шинэчлэлийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Завхан/	2012	2014	488,8	42,2
	Шинэ			267945,2	39220,0
XXVI.1.61	5В магистрал Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2100 метр 2х500мм-ийн шугамыг 2х800 мм болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2015	5820,0	2520,0



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.62	1в магистралийн Тк-1893-с Тк-117 цэг хүртэлх 1500 метр 2х500 мм-ын шугамыг 2х700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2015	3252,3	1500,0
XXVI.1.63	Дарханы дулааны цахилгаан станцад хаягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	2014	2015	8500,9	3000,0
XXVI.1.64	Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих / Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2015	3372,0	1500,0
XXVI.1.65	Дулааны цахилгаан станц 2-ын Р-4 /АК-6/ турбины шинэчлэлийн ажил /Улаанбаатар/	2014	2015	3000,0	1500,0
XXVI.1.66	Аймгийн төвүүдэд шинээр дулааны станц, дулааны шугам барих /Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Архангай, Говь-Алтай, Дундговь, Хэнтий/	2014	2016	160000,0	24000,0
XXVI.1.67	Сумдын төвлөрсөн дулаан хангамж	2014	2016	84000,0	5200,0
	<b>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах</b>			<b>10415,0</b>	<b>2009,0</b>
XXVI.1.68	“ДЦС-4” ХК-ын уур, усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц /Улаанбаатар/	2012	2014	10415,0	2009,0
	<b>Гадаадын зээлээр хэрэгжих дотоод эх үүсвэр</b>			<b>5000,0</b>	<b>1000,0</b>



Дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
		Эхлэх	Дуусах		
XXVI.1.69	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2009	2014	5000,0	1000,0
	<b>Эрчим хүчний яам</b>			<b>560,0</b>	<b>260,0</b>
<b>XXVI.3</b>	<b>III.Тоног төхөөрөмж</b>			<b>560,0</b>	<b>260,0</b>
	Шилжих			560,0	260,0
XXVI.3.1	Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторийг шинээр байгуулах /Улаанбаатар/	2013	2014	560,0	260,0
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>2567529,1</b>	<b>1143275,5</b>

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Хүний хөгжил санд 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, тус сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээ, эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалтыг тогтоох, зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.



**2 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж**

2.1. Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль<sup>2</sup>, Хүний хөгжил сангийн тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН  
ОРЛОГО, ЗАРЛАГА, ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨР,  
ЭРСДЭЛИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ**

**3 дугаар зүйл.** Хүний хөгжил сангийн төсөвт 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 549,780.0 сая төгрөгөөр, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1.	Сангийн сайд	534,780.0
	1.1. Татварын ерөнхий газар	534,780.0
	1.1.1. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.2-т заасан орлого	534,780.0
2.	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд	15,000.0
	2.1. Төрийн өмчийн хороо	15,000.0
	2.1.1. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан орлого	15,000.0

**4 дүгээр зүйл.** Хүний хөгжил сангийн төсвөөс 2014 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 312,064.2 сая төгрөгөөр баталж, төсвийн ерөнхийлөн захирагч нарт доор дурдсан төсөв зарцуулах эрхийг олгосугай:

д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1.	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд	257,453.5
	1.1. Төр хариуцан төлөх эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,033.2
	1.2. Хүүхдийн мөнгө	240,000.0
	1.3. Хөрөнгө оруулалт	5,420.3

<sup>1</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Хүний хөгжил сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2009 оны 45 дугаарт нийтлэгдсэн.



2.	Сангийн сайд	292,326.5
	2.1.Засгийн газрын бонд болон урьдчилгаа төлбөрийн хүүгийн зардал	54,610.7
	2.2.Урьдчилгаа мөнгө, зээлийн үндсэн төлбөрт	157,129.1
	2.3.Засгийн газрын бондын үндсэн төлбөрт	80,586.7
	2.4.Эрсдэлийн нөөц хөрөнгө	0.0

**5 дугаар зүйл.** Хүний хөгжил санд 2014 оны төсвийн жилд хуримтлуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг 0.0 төгрөг байхаар баталсугай.

**6 дугаар зүйл.** “Хүний хөгжил сангийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
БУСАД ЗҮЙЛ**

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн  
тухай хуулийн хавсралт

**ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2014 ОНД  
САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөгөөр/

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд		5,420.3	5,420.3
1.	Хөрөнгө оруулалт		5,420.3	5,420.3
1.1	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3



1.2	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.3	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.4	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014-2014	1,124.3	1,124.3
1.5	Хүүхэд хөгжлийн төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014-2014	923.1	923.1

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2013 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2014 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль<sup>2</sup>, Нийгмийн даатгалын тухай хууль<sup>3</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

<sup>1</sup>Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Нийгмийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.





**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ  
ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

**3 дугаар зүйл.** Нийгмийн даатгалын санд 2014 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1.	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>1,247,206.4</b>
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	507,742.7
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	529,837.8
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	149,211.7
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	2.4
	1.5.Хүний хөгжил сангаас төлөх иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	12,033.2
	1.6.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	22,769.8
	1.7.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	3,000.0
	1.8.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	1,400.0
	1.9.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,101.7
	1.10.Бусад орлого	20,107.0
2.	<b>Сангийн сайд</b>	<b>320,131.3</b>
	2.1.Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	320,131.3
<b>НИЙТ ОРЛОГО</b>		<b>1,567,337.7</b>

**4 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:



Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1.	<b>Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд</b>	
	1.1.Тэтгэврийн даатгалын сан	949,294.4
	1.2.Тэтгэмжийн даатгалын сан	66,611.5
	1.3.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	35,241.4
	1.4.Ажилгүйдлийн даатгалын сан	15,242.1
	1.5.Эрүүл мэндийн даатгалын сан	189,184.8
	1.6.Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны төлбөр	118.9
	1.7.Үйл ажиллагааны урсгал зардал	20,166.9
	1.8.Хөрөнгийн зардал	13,429.3
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>		<b>1,289,289.2</b>

**5 дугаар зүйл.**“Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг хавсралтаар баталсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн хавсралт

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР  
2014 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх, дуусах хугацаа	/сая төгрөгөөр/	
			Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
	<b>Нийгмийн даатгалын ерөнхий газар</b>		<b>26,952.3</b>	<b>13,429.3</b>
<b>1</b>	<b>Хөрөнгө оруулалт</b>		<b>14,271.2</b>	<b>7,483.9</b>
1.1.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2013-2014	999.7	644.2



1.2.	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Өмнөговь, Цогтцэций сум/	2013-2014	517.4	61.9
1.3.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2013-2014	675.8	160.7
1.4.	Цахим мэдээллийн төв, тоног төхөөрөмжийн хамт /Нийгмийн даатгалын сангийн эх үүсвэрээр баригдах цахим архивтай хамтатган цогцоор шийдвэрлэх/ /Улаанбаатар/	2013-2014	6,599.7	1,138.5
1.5.	Нийслэлийн нийгмийн даатгалын газар, нийслэлийн нийгмийн халамж, үйлчилгээний газрын барилга, тохижилт, тоног төхөөрөмжийн хамт /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2014	2,000.0	2,000.0
1.6.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2014	517.4	517.4
1.7.	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	517.4	517.4
1.8.	Нийгмийн даатгалын тасгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2014	517.4	517.4
1.9.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилга /Говь-Алтай, Алтай сум/	2014	1,283.0	1,283.0
1.10.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөл /Баян-Өлгий, Өлгий сум/	2014	139.2	139.2
1.11.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2014	227.2	227.2



1.12.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөл /Хэнтий, Өндөрхаан сум/	2014	250.0	250.0
1.13.	Багахангай дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2014	27.0	27.0
<b>2</b>	<b>Их засвар</b>		<b>873.1</b>	<b>873.1</b>
2.1.	Нийгмийн даатгалын хэлтсийн дээвэр, гадна, дотор талын их засвар /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	286.1	286.1
2.2.	Нийгмийн даатгалын тасгийн барилгын сантехникийн засвар /Хэнтий, Бор-Өндөр сум/	2014	15.0	15.0
2.3.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын дээврийн засвар /Орхон, Баян-Өндөр сум/	2014	30.7	30.7
2.4.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын гадна дулаан шугам хоолойн засвар /Дархан-Уул, Дархан сум/	2014	55.0	55.0
2.5.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын гадна бохир усны засвар /Дорнод, Хэрлэн сум/	2014	5.5	5.5
2.6.	Нийгмийн даатгалын хэлтсийн автомашины гараашийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2014	15.0	15.0
2.7.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын их засвар /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2014	30.7	30.7
2.8.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын сантехникийн засвар /Увс, Улаангом сум/	2014	8.1	8.1



2.9.	Нийгмийн даатгалын хэлтсийн барилгын ханын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	350.0	350.0
2.10.	Худалдаж авсан барилгын дотор талын засвар /Улаанбаатар, Багахангай дүүрэг/	2014	52.0	52.0
2.11.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан конторын барилгын гараашийн засвар	2014	25.0	25.0
<b>3</b>	<b>Тоног төхөөрөмж</b>		<b>11,808.0</b>	<b>5,072.3</b>
3.1.	Хяналтын камер, цахилгаан халаагуур худалдан авах /Улаанбаатар/	2014	214.5	126.0
3.2.	Сервер компьютер, гар компьютер, сүлжээний тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	425.5	425.5
3.3	Нийгмийн даатгалын байгууллагуудын тавилга эд, хогшил /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	657.2	350.0
3.4.	Нийгмийн даатгалын байгууллагуудын автомашины парк шинэчлэл, сэлбэг хэрэгслийн худалдан авалт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014	810.8	470.8
3.5.	Цахим архивын тоног төхөөрөмж	2014	700.0	700.0
3.6.	Эрүүл мэндийн даатгалын ухаалаг “Цахим үнэмлэх” тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2014-2015	9,000.0	3,000.0



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

### **“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36<sup>1</sup> дүгээр зүйлийн 36<sup>1.2</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай” Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Гурав.Дүүргийн прокурорын газар” гэсний 1 дэх заалтын “Баянзүрх дүүрэг” гэснийг “Улаанбаатар хот /зүүн бүс” гэж, 2 дахь заалтын “Сонгинохайрхан дүүрэг” гэснийг “Улаанбаатар хот /баруун бүс” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 11 дүгээр  
сарын 07-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

### **Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2014 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд 2014 онд Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийн хэмжээг доор дурдсанаар тогтоосугай:

1/0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөг.



2.Энэ тогтоолыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын 2014 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай, Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 11 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд  
баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.Төсвийн тогтвортой байдлыг хангаж, гадаад валютын урсгалыг сайжруулан, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх дотоодын



үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, эдийн засгийн бодит салбарыг мөнгөний бодлоготой уялдуулан дэмжиж ажиллахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.

3.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/санхүүгийн зах зээлийн бүтцийг олон тулгуур бүхий, зохистой болгох, чөлөөт өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох, санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэх чиглэлээр 2014-2016 онд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/эдийн засгийн бодит салбарын идэвхжлийг дэмжих зорилгоор “Зээлийн хүү буурах орчныг бүрдүүлэх” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

3/бичил, жижиг, дунд бизнесийн санхүүжилтийг дэмжиж ажиллах;

4/валютын захад тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах;

5/валютын захад банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн бусад оролцогчийг идэвхтэй оролцуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах санхүүгийн үүсмэл хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэх зорилгоор валютын арилжааны тогтолцоог бий болгох;

6/Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч ажиллах.

4.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газар, Монголбанкны хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт иж бүрэн дүн шинжилгээ хийх, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, арга хэрэгслийг зах зээлийн механизмд суурилсан хэлбэрт шат дараатай шилжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулах, хөтөлбөр





хэрэгжиж байгаа салбарт өрсөлдөөний шударга бус орчин бий болохоос урьдчилан сэргийлэх, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах;

2/улсын гадаад өр, түүний эргэн төлөлтийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулж, эрсдэлээс хамгаалах механизм бий болгох;

3/төсвийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл боловсруулахад ашиглах төрөгийн гадаад валюттай харьцах ханшийн төсөөллийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн боловсруулах.

5.Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай:

1/Монгол Улсын зээлжих зэрэглэл, түүний өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээг тогтмол хийж, зээлжих зэрэглэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлд танилцуулж байх;

2/Монголбанкны хараат бус байдлыг бэхжүүлэх, засаглалын бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор хараат бус гишүүд бүхий мөнгөний бодлогын зөвлөлийг бий болгох чиглэлээр Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах;

3/Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүн, шийдвэр гаргах механизм, хариуцлагын тогтолцоог сайжруулах, зөвлөлийн бүрэлдэхүүнийг өргөтгөх, санхүүгийн салбарт үүсч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнээс хамгаалах бодлогын уялдааг хангах үр дүнтэй институци болгох чиглэлээр Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах.

6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль тогтоомжийг Олон улсын байгууллага /ФАТФ/-аас тогтоосон стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх, Монгол Улсын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулах, холбогдох журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.

7.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.



8.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

Монгол Улсын Их Хурлын 2013 оны  
62 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР  
2014 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлогын гол зорилт нь инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, бодит салбарын идэвхжлийг мөнгөний бодлогоор дэмжих замаар эдийн засгийн дархлааг сайжруулахад чиглэнэ.

**1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:**

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2014 оны эцэст 8 хувь, 2015-2016 онд 7 хувиас хэтрэхгүй түвшинд байлгана. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу инфляцийг хязгаарлах, мөнгө, төсвийн бодлогын харилцан уялдааг хангах чиглэлээр Засгийн газартай хамтран ажиллана. Эдгээрийн үр дүнд дунд болон урт хугацаанд макро эдийн засаг тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих зарчим баримтална.

1.3.Гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулах тогтолцоог бүрдүүлнэ.

**2.Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:**

2.1.Банкуудын төлбөрийн чадварыг хадгалж, системийн шинжтэй эрсдэлээс хамгаалах чадавхыг нэмэгдүүлнэ.

2.2.Олон улсад мөрддөг зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагаатай уялдуулан, эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг сайжруулна.



2.3.Банкны эрсдэл, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор банкны зээлийн барьцаа хөрөнгийн болон зээл, хүүгийн зардлыг нэмэгдүүлж байгаа бусад хүчин зүйлийн нөлөөллийг бууруулах эрх зүйн орчныг шинэчилнэ.

### **3.Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1.Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган, төлбөр тооцооны системийн шинэчлэлийг 2014-2016 онд эрчимжүүлнэ.

3.2.Санхүүгийн зах зээлийн харилцагчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран эхлүүлнэ.

3.3.Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаа, арга хэрэгслийн ил тод, нээлттэй байдлыг хангах, гаргасан шийдвэрийг олон нийт, бизнес эрхлэгчдэд хүртээмжтэй хүргэх замаар бодлогын үр нөлөөг сайжруулна.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 11 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын төсөв, санхүүгийн өнөөгийн нөхцөлд бодитой дүгнэлт хийж, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, түүнд тавих хяналтыг чангатгах шаардлагатай байгааг тэмдэглэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай:

1/Улсын төсвийн урсгал зардлыг хэмнэсэн тохиолдолд түүнийг ажилтан, албан хаагчдын үр дүнгийн урамшуулалд зарцуулах эрхийг төсвийн захирагч нарт олгох журам батлан мөрдүүлж ажиллах;



2/Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгааныг нарийвчлан тогтоосны дараа тэдгээр төсөл, арга хэмжээний санхүүжилтийн саналаа төсвийн тодотголд тусган 2014 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Улсын Их Хурлын 2008 оны 47 дугаар тогтоолоор батлагдаж, эргэн төлөх нөхцөлтэйгөөр хэрэгжсэн төслүүдийн гүйцэтгэлийг үндэслэн улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллах;

4/“Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд сумын төвийн цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж, цахилгаан шугам сүлжээ, дулааны нэгдсэн хангамжийг тэргүүн ээлжинд шийдвэрлэх;

5/Монгол Улсын 2013 оны төсвийн тодотголоор хасагдсан, 2014 оны улсын төсөвт тусгагдаагүй болон бусад зам тээвэр, эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөвт цалин, урамшууллын зардлыг 15.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбогдуулан шүүгчдийн цалин, нэмэгдлийн хэмжээг Улсын Их Хурлаар батлуулахыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

3.Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгааныг нарийвчлан тогтоож, дүгнэлт гарган 2014 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд танилцуулахыг Үндэсний аудитын газар /А.Зангад/-т даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн байнгын хороо /Ц.Даваасүрэн/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 9.75

**Индекс: 14003**